

ӨВӨРМӨЦ ХЭЛЦ НЬ ЗҮЙРЛЭЛ (metaphor) БА
ТӨЛӨӨЛӨЛ (metonym) БОЛОХ НЬ

Э. Тогтуун*

Өвөрмөц хэлцийг уламжлалт хэлшинжлэлийн онолд утга зүйн асуудлын хүрээнд оруулан судалдаг тухай бид сайн мэдэж байгаа. Гэхдээ түүнийг томъёолон нэрлэсэн нэр томъёог авч үзэхэд хэд хэд байдаг бөгөөд энэ нь өвөрмөц хэлцийн судалгаа нэгдсэн ойлголтод хүрээгүй байгааг харуулж байна гэж хэлж болмоор. Өвөрмөц хэлцийн талаарх өмнөх судалгааг нэгтгэн үзэхэд хэд хэдэн нэр томъёог хэрэглэж байгааг харж болно. Үүнд:

1. Өвөрмөц хэлц
2. Хэвшмэл хэллэг
3. Шууд бус нэрлэлт
4. Тогтвортой холбоо үг

1. Өвөрмөц хэлц: Хэлц гэдэг нь хэлхэлдэн цуварсан нэг хэсэг үгс гэсэн утгыг илэрхийлж байна. Өвөрмөц гэдэг нь тухайн бүтцийг бүрдүүлж буй үгсээр илрэн гарах утга нь хэвийн бус, гаж байна гэсэн санааг гаргаж байна.

2. Хэвшмэл хэллэг: Энэ нэр томъёо бол тодорхой хугацааны дотор үүсэн бий болсон мөчөөс эхлэн тасралтгүй идэвхтэй хэрэглэгдэж байгаа гэсэн санааг гаргана.

3. Шууд бус нэрлэлт: Энэ нэр томъёо нь тухайн хэллэгээр илэрч буй ухагдахуун бол бодот бус юмс үзэгдлийн тухай ойлголтыг өгдөг гэдгийн томъёолол юм.

4. Тогтвортой холбоо үг: Гадны ямар нэгэн нөлөөнд өртөж, бүтэц болон утгын хувьд эвдрэхгүй гэсэн утгыг гаргана.

Эдгээр 4 нэр томъёо нь өнгөц харахад өөр өөр ухагдахууныг илэрхийлж байгаа мэт боловч угтаа нэг зүйлийн өөр өөр өнцгийн судалгаа юм. Юмс үзэгдэлийн мөн чанар нь дараах 4 шинж чанартай байдгийг судлаач Л. Хүрэлбаатар¹ дурдсан байдаг. Үүнд:

1. Оршин ахуйн язгуур – Хэв шинжит нөхцөл байдал
2. Үйлс – Хөгжил хувьсал

*Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, соёлын сурууль

¹ “Дуун утгын яруу зохист” Л.Хүрэлбаатар. Мөнхийн үсэг ХХК. Улаанбаатар 2005 он.

3. Эрдэм – Ид шид чадлыг нээх

4. Эд – Онцлог мөн чанар

Үүнийгээ модны мөн чанараараа баталгаажуулсан байдаг.

А. Мод нь газарт үндэстэй, газраас дээш гол иштэй байх.

Б. Ургаж цэцэглэх, найгаж ганхах, хатаж шарлах.

В. Үнэр өнгөөрөө баясаан цэнгээх, сэрүүцүүлэх.

Г. Тухайн тухайн модонд байдаг өвөрмөц ялгамж шинжээрээ онцгойрох.

Энэ шинж чанар тухайн нэг юмс үзэгдэлд бас оршин байдаг.

Хэлц бол бүтэц

Хэвшмэл хэллэг бол цаг хугацаа

Өвөрмөц хэлц бол утга

Шууд бус нэрлэлт бол хийсвэрлэл


Тогтвортой холбоо үг бол үзэгдэл

Бид хэлний өнгөн ба гүн бүтцийн тухай их ярьдаг. Энэ бүтэц “Өвөрмөц хэлц”-д бас байгааг эндээс харж болмоор санагдана.

Тогтвортой холбоо үг ба Хэвшмэл хэллэг бол өнгөн бүтэц.

Өвөрмөц хэлц ба Шууд бус нэрлэлт бол гүн бүтэц.

Үүнийг бүтцэд оруулвал дараах маягтай болно.



Дээрх бүтцээс харахад бидний олон янзаар томъёолсоор ирсэн дээрх нэр томъёо бүхий бүлэг үгсийг уламжлалт хэлшинжлэлд нийлэмж бүтэц бүхий үгс болон түүнээс илрэн гарах утгын ээдрээтэй байдлаас хамааран хэлшинжлэлийн судалгааны объект гэж үзэхээсээ илүүтэй утга судлалын асуудал руу оруулдаг байсан юм.

Тэгвэл бидэнд энэ бүлэг үгсийг өөр өнцөгөөс харж судлах боломж бас байна. Энэ бол Танихуйн хэлшинжлэл юм. Танихуйн хэлшинжлэлд хэлийг “бодит ертөнцийг тусган харуулдаг толь” гэдэг өнцгөөс нь бус, харин “хүн түүнийг хэрхэн таниж, задлан ялгадаг тухай болон түүнийгээ хэлээр хэрхэн илэрхийлдэг вэ гэдгийн тусгал юм” гэсэн өнцгөөс нь харж судалдаг юм.

Бидний энд асуудал болгон яриад байгаа “Хэсэг бүлэг үгс” бол ямар ч улс үндэстний хэлэнд оршин байдаг, юмс үзэгдэл, хэрэг явдлын үр дүнд бий болсон, тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл яах аргагүй мөн юм. Энэ утгаараа танихуйн хэлшинжлэлийн судлах ёстой объектын нэг мөн гэж хэлж болно.

Танихуйн хэлшинжлэлд метафор² ба метоними³ гэдэг нэр томъёо байдаг тухай болон тэр нь маш нарийн бүтэцтэй хүний юмс үзэгдэлийг танин мэдэх үйл ажиллагааны нэг болох тухай бид “Метафор ба танихуй хэлшинжлэл”⁴ өгүүлэлдээ бичсэн билээ.


Түүнийг сануулах үүднээс загварчлалыг дахин оруулья.



Метафортой зэрэгцээд Метонимийн тухай бас тайлбарлах ёстой. Метафор нь хоорондоо хамааралгүй хоёр ухагдахууны дунд явагдах дүрслэн буулгалт байдаг бол Метоними нь ижил төсөөтэй ухагдахуун дунд хийгддэг дүрслэн буулгалт юм.

Метонимийн загварчлал

Жишээгээр тайлбарлая.
“Цас” гэдэгтэй үгтэй холбогдон
гарах бусад төсөөлөл



Эндээс харахад метафор бол харьцуулж буй хоёр зүйлийнхээ ижил төсөөтэй шинжийг онцлон гаргахыг зорьдог байхад метоними бол нэг ухагдахуунд багтаж байгаа хоёр зүйлийн хоорондоо адилхан байгааг харуулахыг зорилгоо болгодог. Уламжлалт хэлшинжлэлд тэмдэг нэрийн харьцуулсан зэргийн талаар маргаантай асуудлууд багагүй байдаг. Тухайлбал зэрэг мөн эсэх тухай болон утгын эрчимжилт бууралт гэх зэрэг асуудлууд байдаг. Өнөөг хүртэлх

² Метафор бол уламжлалт хэлшинжлэлийн онолоор авч үздэг найруулга зүйн асуудал биш төдийгүй хүний юмс үзэгдлийг танин мэдэх аргуудын нэг юм гэдгийг Жорж Лакофф 1980, 1987, 1990, 1993 оны бүтээлүүддээ тусгасан байна.

³ Метафороос арай хожуу гарч ирсэн ухагдахуун бол Метоними бөгөөд бидний юмс үзэгдлийг танин мэдэх явцад хэрэглэгддэг үндсэн арга барил юм.

⁴ “Метафор ба танихуй хэл шинжлэл” Э.Тогтуун. Монгол судлал № 2010 он.УБ

Метонимийн тухай ойлголтоос харахад хоёр янз байна.

Нэг ойлголт нь “Хамаарал”-ыг чухалчлан үздэг байна. Энэ нь найруулга зүйн уламжлалаа хадгалсан, хоёр юмсын бодит ертөнц эсвэл утгад байх ойрын холбоо хамааралд авч үзэх үзэл юм. Тухайлбал: Бидний “тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг” хэмээн томъёолж дадсан тодорхой бүтэц бүхий хэллэг болон “харьцуулсан зүйрлэсэн найруулга” гэж нэрлэдэг хэллэг зэргийг нэрлэж болмоор санагдана.

Нөгөө ойлголт бол танихуйн хэлшинжлэл үүсэн хөгжих явцад бий болсон үзэл болно. Одоо дээрх хоёр бүтэц өвөрмөц хэлцэд байгаа эсэхийг харцгаая. Өвөрмөц хэлцийг ажиглахад, тэдгээрийн ихэнх нь тухайн хэлцийг бүтээж буй үгийн утгаас нь тодорхой нэг учир шалтгааны холбоосыг олж харах боломжтой. Ялангуяа нэг үгийг цөм болгосон хэсэг бүлэг хэлц хэллэгт утга болон бүтцийн бүхэл систем байгааг олж харж болно. Тэрхүү системийг буй болгож байгаа зүйл бол бид бүхний юм үзэгдлийг таних системийн нэг болох метафор ба метоними билээ. Метоними болон Метафор бол харилцан нөлөөллийн хамааралтай байдаг. Энэхүү харилцан нөлөөллийг бий болгож байгаа гол хүчин зүйл бол Метоними нь Метафорыг бий болгох гол суурийг тавьж өгдөг гэсэн хамаарал юм.

Өвөрмөц хэлцэд дээрх хамаарал байна гэдгийг тодорхой болгохын тулд Монгол-Япон хэлний “ам” орсон хэлцэд ажиглалт хийж, задлан шинжилж, тус хоёр хэлээр яригч үндэстний “Ам”-ыг ойлгох ойлголтод ижил төсөөтэй болон ялгаатай өөр шинж байгаа эсэхийг хэл соёлын үүднээс олж гаргахыг оролдъё. Учир нь юмс үзэгдлийг метафорлох эсвэл метонимилэх гэдэг энэхүү танин мэдэхүйн үйл ажиллагаа нь өнгөн хэсэгтэй ижил төсөөтэй эсвэл өөр ялгаатай хоёр зүйлийн харьцуулал зүйрлэл мэт харагдавч, гүн хэсэгтэй хүний юмс үзэгдэлд хандах хандлага, үнэлэмжийг агуулж байдаг маш нарийн процесс байдаг юм.

Хоёр хэлний “ам” бүхий метафорыг нэгтгэн авч үзэхэд монгол хэлэнд 69, япон хэлэнд 91 хэллэг бүртгэгдлээ. Танихуйн хэлшинжлэлийн үндэс суурийг тавьж, түүнийг дэлхийн түвшинд хүртэл хөгжүүлж чадсан Жорж Лакофф метафорын төрөл зүйлийн талаар ангилахдаа хүний бие эрхтний нэр оролцсон метафор олон байдаг тухай дурдсан байдаг.

Цаашлаад японы судлаач Т.Оохори метафор болон метонимийн төрөл зүйлийг 4 хувааж үзсэн байдаг.⁵ Тухайлбал:

1. Conventional metaphor-дадал заншлын метафор
2. Generic metaphor – нийтлэг метафор
3. Image metaphor-төсөөллийн метафор
4. Яруу найргийн метафор

Бидний энд дэлгэрэнгүй задаргаа хийх зорилгоор жишээ болгон авч буй метафор нь 1-р ангилал буюу дадал заншилын метафорт багтана. Т.Оохори тус метафорыг дараах маягаар тайлбарлаж байна.

“Conventional metaphor бол өдөр тутмын үйл явдалтай нарийн холбоотой, нэг ухагдахуун доторх мэдлэг мэдээлэлд суурилан бий болдог дадал заншлын шинжтэй метафор юм. Олон нийтийн дунд өргөн дэлгэр тархаж, өдөр тутам хэрэглэгдэж байдаг.

⁵ Танихуйн хэлшинжлэл. Т.Оохори. Япон Токио. 2000 он.

Хүн, ургамал зэрэг бодит ухагдахуун болон агуулга бүхий мэдээлэлтэй зүйрлүүлэн, түүнийгээ хийсвэрлэн буулгасан бүтэцтэй байдаг. Энэ төрлийн метафорыг хүн байнга хэрэглэж байдаг тул түүнийг дүрслэн буулгалтын холбоо хамаарал дундаас бүрэлдэн бий болдог гэдгийг төдий л анзаардаггүй.”

Ийм шалтгааны улмаас хоёр хэлний “ам” бүхий метафор нь “Дадал заншлын метафор”-т багтана. Нөгөөтэйгүүр аливаа хүний хэлэнд “нүх”, “ул мөр”, “алдах”, “амрах” гэсэн ямар нэгэн зүйл нь дутагдаад байгаа санааг илэрхий харуулсан үгс олон байдаг. Хийсвэрлэн бодоод үзэхэд, “нүх” гэдэг нь эд юм адил оршин байдаггүй. Бодитоор байгаа зүйл бол амсар юм. Харин бид амсраар хүрээлэгдсэн юу ч байхгүй хэсгийг байгаа мэтээр “нүх” хэмээн ойлгодог юм⁶ болов уу. Иймэрхүү төрлийн үгийг 1952 онд Лейси⁷ “Дутмаг үг” гэж нэрлэсэн байдаг. Хоёр хэлний метафорыг харьцуулан үзэхэд “ам бол нүх” гэсэн ойлголт маш тод томруун туссан байгааг харж болно.

1. Хэлцийн Метоними болох нь

1.1 Амны нээгдэх хаагдах хөдөлгөөнд тулгуурласан метоними

Ам бол нээгдэх хаагдах хөдөлгөөн бүхий “нүх” мөн. Хоёр хэлний “нээгдэх хаагдах хөдөлгөөн бүхий нүх”-ний амыг нээх хаах гэсэн хөдөлгөөн хийснээр аль аль нь “хэлэх ярих” гэсэн утгатай метонимийг үүсгэсэн байна. Жишээлбэл: ам нээх—口を開く, ам хаах—口を閉ざす, ам таглах—口をふさぐ

Энд байгаа метонимийг ажиглахад, монгол япон хэлээр яригч үндэстнүүдийн “нүх”-ийг ойлгох ойлголтыг мэдэж болмоор санагдана. “Нүх” бол гадны ямар нэг үйлдлийн үр дүнд бий болдог зүйл гэсэн ухагдахуун аль аль хэлний метонимид байгаа нь сэтгэлгээний хувьд ижил байгааг харуулах мэт санагдана. Цаашлаад нэгэнт бий болсон “нүх”-ийг “нээх, хаах” нь хамгийн энгийн хөдөлгөөн байдаг байна.

Харин нэг ялгаатай зүйл бол Монгол хэлний метонимид буй “Ам ангайх” гэсэн хэллэг юм. Энэ нь “онгорхой нүх”-ийг үзэх монголчуудын үзлийг тусгасан мэт санагдана. Манай үгийн санд “онгойж явахаар умайж яв” гэсэн хэллэг байдаг. Энэ бол “нүх”-нд өгөх үнэлэмжийг харуулж байна. Бодит байдалд тулгуурлах үзэл энд үйлчилж байна.

1.2 Амны нээгдэх хаагдах хөдөлгөөнд тулгуурласан метоними

Энэ хэсгийн метоними нь “нээх хаах” үйл хөдөлгөөн бүхий үгнээс салаалан гарах утга бүхий үгтэй холбогдсон байна. Эдгээр метонимийг ажиглахад хоёр утгатай байна. Үүнд:


1. “Хэлэх ярих” үйлдлийн хүрээнд өөрөөр хэлбэл “хэлж ярьж буй байр байдал”-ыг илэрхийлсэн утга. Энэ утга нь япон хэлэнд байна. Харин монгол хэлэнд байхгүй байна. Тухайлбал: 口から出る Амнаас гарах \Хэлэх ярих\, 口をつく、ついで出る Ам дагаж гарах \Үг хэл нь ар араас нь цувран гарах\, 口に出す Аманд гаргах \Үг болгож ярих\, 口を出す Амыг гаргах \Бусдын ярианд хажуугаас орж саналаа хэлэх\, 口ごもる Аманд ороод гарахгүй байх \Ээрэх, ярьж чадахгүй байх\

⁶ Танихуйн хэлшинжлэл. Т.Оохори. Япон Токио. 2000 он.

⁷ Ernst Leisi 1918-2000 хүртэл амьдарсан хэл шинжээч. Утга судлалын чиглэлээр судалгаа хийсэн байна.

2. “Хэлэх ярих” үйлдэл хийгдсэний дараах үр дүнг илэрхийлсэн утга. Энэ утга хоёр хэлтний аль алинд байна. Тухайлбал: Ам алдах- 口外する, амьг нь үдэх-口を封じる, амаа барих-口止めする


1-р утгын хүрээнд япон хэлээр яригч ард түмний “нүх” -ийг ойлгох ойлголтыг олж авахыг оролдъё. Дээрх метонимигээс харахад “Нүх бол орж гарч болдог орон зай юм” гэсэн ухагдахуун япон хэлтэнд байгаа мэт санагдана. Янз бүрийн нүх суваг руу орж гарах үйлдэл нь тухайн нүхний бартаа саадны их багаас хамаарна гэсэн туршлагад тулгуурласан үзэл энд үйлчилж байна. Газар тариалан эрхэлдэг, суурин амьдралтай ард түмний хувьд “нүх” бол тодорхой хэмжээгээр үүрэг гүйцэтгэдэг болов уу. Монгол-Япон хэлээр яригч үндэстний “ам” бүхий метонимийг нэгтгэхэд дараах байдалтай байна.




2. Хэлцийн Метафор болох нь

2.1 Нээгдэх хаагдах хөдөлгөөн бүхий нүх бол сав мөн Метафор

Нээгдэх хаагдах хөдөлгөөн бүхий нүх маань ямар нэг зүйлийг агуулдаг “сав суулга”-ыг төлөөлж, шинж чанарын нэр бүхий үгтэй холбогдсоноороо тухайн сав суулганы чанар чансааг илэрхийлсэн утга бүхий хэллэг болсон байна. Ингэснээрээ хүний зан чанарыг тодорхойлсон утгыг төлөөлүүлэн гаргах болсон байна. Өөрөөр хэлбэл “ам бол сав” гэсэн метафор бий болж, хүний зан чанарыг сав суулганы харагдах байдлаар төлөөлүүлжээ. Үүнийг загварт оруулбал:






Монгол-Япон хэлтний хүний зан аашийг тодорхойлсон “Ам” метафорыг харьцуулан, загварчлахад дараах маягтай байна.




2.2 Нээгдэх хаагдах хөдөлгөөн бүхий нүх бол сав мөн Метафор

Энэ хэсгийн жишээнүүдийг харахад “ам бол сав” метафор нь хөдөлгөөн заасан утга бүхий үгтэй холбогдон, тухайн “сав суулгыг ашиглах” гэсэн хэллэгээр “хэлэх ярих үйлдлийг ямар нэгэн зүйлд санаатайгаар ашиглах” гэсэн санааг төлөөлүүлэн гаргаж байна.



2.3 Нээгдэх хаагдах хөдөлгөөн бүхий нүх бол сав мөн Метафор

Энэ хэсгийн метафорыг ажиглахад, “сав”-ны язгуурын шинж чанар нь гадны ямар нэг үйлчлэлийн нөлөөгөөр өөрчлөгдөн хувирч, ингэснээр ач тусаа алддаг байдлыг ажиглан харж, түүгээр хүний үйл ажиллагаа, зан байдлын өөрчлөлтөд ч гэсэн гадны нөлөө багагүй хувийг эзэлдэг гэдгийг илэрхийлсэн байна.



Монгол-Япон хэлтэний “Ам”-ны “хэлэх ярих” утга бүхий метоними болон метафороос харагдаж байгаачлан зарим нэг төлөөллийн ялгааг эс тооцвол бүтэц болон утгын хувьд адил байгааг бид олж мэдлээ.

Нэг ухагдахуун хоёр болон түүнээс олон зорилгоор хэрэглэгдэх нь цөөнгүй бий. Энэ үзэгдлийг танихуйн хэлшинжлэлд “schema” буюу схемлэл эсвэл хийсвэрлэл хэмээн томъёолдог байна. Хүний оюун ухаанд байдаг танин мэдэхүйн чадвар бол доорх 4 чадвар болно.

1. Харьцуулж зэрэгцүүлэх чадвар
2. Категорилох чадвар
3. Зүйрлүүлэх чадвар
4. Таамаглал дэвшүүлэх чадвар

Хүн өөртөө байгаа эдгээр чадвараа ашиглан “хийсвэрлэн сэтгэх арга”-аа хөгжүүлж, өнөөдрийг хүртэл гараад байгаа агуу их нээлтүүдээ хийж чадаж байгаа юм.

Энд нэг зүйл дээр тогтож ярихыг оролдъё. “Хүний танин мэдэхүйн чадвар” дээр тулгуурласан “хийсвэрлэх арга”. Өөрөөр хэлбэл хүний тархины үйл ажиллагаа бол чадвараар илэрдэг. Түүнийг бодот илрэл бол арга байдаг. “Чадвар” ба “Арга” хоёр хүний танин мэдэхүйн үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Тиймийн тул, хийсвэрлэн сэтгэх аргын тухайд, өөрийн дүгнэлтийг хийхэд, нэг талаас харахад, аливаа юмс үзэгдлийн мөн чанарыг танин мэдэхэд зайлшгүй ашиглагддаг шинжлэх ухааны аргуудын нэг болохынхоо хувьд хүний зохион гаргасан зүйл мөн боловч, нөгөө талаасаа хүний тархины үйл ажиллагааны нэг хэсэг болдгийг нь харвал хүний оюун ухаанд байдаг зүйл гэж хэлж бас болмоор санагдана.


Хүн өөрийн туулж өнгөрүүлсэн дадлага туршлагаараа дамжуулан, өөрийн мэдлэгээ байнга шинэчлэн өөрчилж байдаг. Ер нь мэдлэг олж авна гэдэг процесс нь гаднаас мэдээллийг олж, урьд нь байсан мэдээллийнхээ санд нэмж оруулах явдал юм. Ингэхдээ ихэнх тохиолдолд мэдлэг нь, хэд хэдэн бодот мэдээллийн хооронд харьцууллыг хийсний дараа, бодот эс бөгөөс

хийсвэр хэлбэрээр оюун ухаанд буудаг. Үүнийг хийсвэрлэл гэж нэрлэдэг.⁸ Энэхүү хийсвэр шинж чанар бүхий мэдлэгээ хийсвэрлэх аргын тусламжтайгаар бодот болгодог. Тийм учраас аливаа юмс үзэгдлийн мөн чанарыг мэдэхэд хийсвэрлэх арга зайлшгүй хэрэгтэй байдаг.

1. “Ам бол сав” метафорын “идэх уух” гэсэн утгыг гаргах нь

Хоёр хэлний “Ам” бүхий метафорт “Ам”= “идэх уух” гэсэн утга байгааг харж болно. Өөрөөр хэлбэл “нээгдэх хаагдах хөдөлгөөн бүхий нүх” бол “Сав” мөн гэсэн метафор нь ямар нэг зүйлийг агуулдаг, мөн “нээгдэж хаагддаг” хөдөлгөөн хийдэг гэсэн утгыг илэрхийлэх тул “идэх уух” үйлдлийг бас хийнэ хэмээн ойлгосноороо хоёр хэлтний “ам”-ыг үзэх үзэл ижил байгааг харж болмоор санагдана.

Энд байгаа Монгол – Япон хэлний метафорыг харахад, “сав” –ыг идэх зүйлээр их байлгах уу, аль эсвэл амттан шимттэнээр дүүргэх үү гэдэг ойлголт ялгаатай байгааг харж болмоор санагдана. Өөрөөр хэлбэл “савны дүүрэн” байдал буюу “хэлбэр”-ийг эрхэмлэх монгол үзэл, “саван доторхийг юугаар дүүргэх вэ” буюу “агуулга”-ыг эрхэмлэх япон үзэл хоёр эсрэгцэж байна.




“Ам бол сав” метафорын “Амьдрал” гэсэн утгыг илэрхийлэх нь

“Сав” нь тостой устай байна гэдэг маш аз завшаантай хэрэг явдал мөн гэдэг үзэл монгол-япон хоёр хэлтний аль алинд байгаа нь эндээс харагдаж байна.

⁸ Танихуйн хэлшинжлэл. Оохори Тошио. Токио 2000.

Эх сурвалжийн хүрээ

Зорилгын хүрээ



Монгол болон Япончууд “ам”-ыг “сав, нүх” гэж ойлгох болсон шалтгааны талаар өөрийн тайлбарыг хийхийг оролдъё. Монголчууд бид өөрийн амьдарч буй энэ орон зайгаа “сав шимийн ертөнц” хэмээн нэрийддэг. Энэ нь Бурханы шашны “Гадаад сав ертөнц хийгээд дотоод шим ертөнцийн хамаг амьтан багтдаг” гэсэн үзэлтэй шууд хамааралтай ойлголт бөгөөд үүнтэй холбоотойгоор “ам”-ыг “сав”-аар зүйрлүүлсэн юм болов уу хэмээн санана. Япончуудын тухайд гэвэл тэд МЭ-ний 4,5-р зууны үед Хятад болон Солонгосоор дамжуулан Бурханы шашныг өөрийн орондоо оруулан шүтэх болсон ба энэ утгаараа Монголчууд биднээс өмнө Бурханы шашинтай болсон болов уу. Тийм учраас бидний энд яриад байгаа “сав шимийн ертөнц” гэдэг ухагдахууны тухай ойлголт ерөнхийдөө ойролцоо байх үндэслэл байгаа хэмээн бодно. Учир юу вэ гэвэл энэ өгүүлэлд жишээ болгон авч, задлан шинжилсэн “ам” бүхий метафор ба метонимид байгаа бүтэц болон утгын ижил төсөөтэй шинж тодорхой хэмжээгээр дээрх санааг батлах нотолгоо болно гэж бодно.

Тэгэхээр “хүн”-ий биеийн гадаад хэлбэр бол “гадаад сав ертөнц” болох бөгөөд доторх эрхтэн нь түүнийг тэжээгч “дотоод шим ертөнц” болно. Энэ тохиолдолд дотоод гадаад ертөнцийг холбох үүргийг гүйцэтгэх ямар нэгэн зүйл зайлшгүй оршин байх шаардлага гарч ирнэ. Энэ үүргийг “ам” гүйцэтгэж байна. Бурханы номонд “савын гурван гэм”⁹ гэж байдаг байна. Ном сонсогч шавийн гурван гэм болбоос:

1. Чих үл тавин сонсох хөмөрсөн савын гэм
2. Сэтгэлдээ үл барих цоорхой савын гэм
3. Нисваанис лугаа холилдсон хортой савын гэм

Энд дурьдсан “савын гэм” нь дээрх задаргаатай адил байгааг бас харж болно. Хоёр хэлэнд байгаа метафор дотроос нэгэн сонирхолтой жишээг авч үзье.

- | | |
|-------------------------|------------------------------|
| Амны нь салиа арилаагүй | 口なお乳臭 \Ам нь сүүн үнэрээрээ\ |
| А. Бага нялх, балчир | Нас залуу, туршлагагүй |
| Б. Туршлагагүй | |

⁹ Буддын шашин соёлын тайлбар толь. Буддын судлал Цуврал 2-р дэвтэр. УБ 1999 он.

Тус хоёр метафор нь “сав” гэсэн утгыг гаргаж байгаа боловч бусад метафорт хэрэглэгдэж буй “сав”-наас арай өөр “сав”-ыг хэлж байгаа нь илэрхий байна. Өөрөөр хэлбэл “сав” нь хэрэглээ болоод үүргээсээ хамааран хэмжээ ба хэлбэрийн хувьд янз бүр байдаг гэдгийг бидэнд хэлж өгч байгаа шиг санагдана. Тэгэхээр энэ талаар бурханы номонд хэрхэн юу гэж тайлбарласан байдаг тухай сонирхон үзье.

Бурханы шашинд савын их, бага нугуудыг хэмжих ёс гэж байдаг ба “Илт номын сан”-ийн хэмжих ёс хамгийн эрхэм юм байна.¹⁰ Тухайлбал: маш нарийн тоосон, нарийн тоосон, төмрийн тоосон, усны тоосон гэх мэтээр маш нарийвчлалтай хуваан үздэг байна.

Эцэст нь нэгтгэн хэлэхэд “Хэлц”-ийн энэ нарийн бүтэц болон утгыг судлан гаргахад уламжлалт хэлшинжлэлийн арга учир дутагдалтай болохыг та бүхэн эндээс олж харж байгаа болов уу. Тиймээс “хэлц”-ийн үнэн мөн чанарыг олж гаргахын тулд бидэнд түүнийг “метафор болон метоними” гэсэн нэр томъёон дөр танихуйн хэлшинжлэлийн судалгааны аргаар судлах зайлшгүй шаардлага байгааг хэлэх юун.

¹⁰ Буддын шашин соёлын тайлбар толь. Буддын судлал Цуврал 2-р дэвтэр. УБ 1999 он

Summary

Through this article, we attempted to explain some phrases using the word 'Ama' in Japanese and Mongolian in comparative and cognitive linguistics. Researching phrases through traditional linguistic and semantic approaches, that is to say, isolating them from the relation from others, cannot entirely reveal their real nature. As a result, we have faced the regular demand of research while evaluating the phrases under the cognitive linguistic definition of 'metaphor' and 'metonym'.

Ашчгласан ном

1. “Дуун утгын яруу зохист” Л.Хүрэлбаатар. Мөнхийн үсэг ХХК. Улаанбаатар 2005 он.
2. Танин мэдэхүйн хэлшинжлэл. Оохори Тошио. Токио. 2002.
3. Метафор ба танихуй хэлшинжлэл” Э.Тогтуун. Монгол судлал № 2010 он.УБ
4. Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь. Г.Аким. УБ 1982 он.
5. Монгол хэлний тайлбар толь Я.Цэвэл. УБ
6. Япон хэлний зүйр цэцэн үг, хэлцийн толь. Сансээдоо. Токио 1999 он.
7. Буддын шашин соёлын тайлбар толь. Буддын судлал Цуврал 2-р дэвтэр. УБ 1999 он.